

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2021 оны 11 сарын 15 өдөр

Дугаар A/52

Арвайхээр сум


Г Эрүүл мэндийн газрын дэргэдэх
“Жендерийн дэд зөвлөл”-ийн
бүрэлдэхүүн батлах тухай Г

Жендерийн эрх, тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн “Дүрэм шинэчлэн батлах” тухай 227 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн “Эрүүл мэндийн салбар дах жендерийн эрх, тэгш байдлыг хангах бодлого батлах тухай” A/625 дугаар тушаалын тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн газрын дэргэдэх “Жендерийн дэд зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журам, чиг үүргийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Зөвлөлийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллахыг дэд зөвлөлийн дарга (М.Золзаяа)-д үүрэг болгосугай.
3. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг санхүүжүүлэхийг ерөнхий санхүүч (Б.Валя)-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Н.ОЮУНТУЯА

Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны
11 дүгээр сарын .../...-ны өдрийн .../... дүгээр
тушаалын нэгдүгээр хавсралт



“ЖЕНДЭРИЙН ДЭД ЗӨВЛӨЛ”-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дэд зөвлөлийн дарга:

Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл
мэндийн хэлтсийн дарга

Гишүүд:

Эрүүл мэндийн газрын Хүний нөөцийн
бодлого, төлөвлөлт, нийгмийн баталгааны
асуудал хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Халдварт бус өвчний
асуудал хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн
боловсрол, мэдээлэл, сургалт, сурталчилгаа
хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Анхан шатны тусlamж
үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн


Эрүүл мэндийн газрын Хяналт, шинжилгээ,
үнэлгээ, мэдээллийн хэлтсийн Статистик,
мэдээлэл хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Эдийн засагч

Эрүүл мэндийн газрын жолооч

Нарийн бичиг:

Эрүүл мэндийн газрын Өсвөр үе, нөхөн
үржихүйн эрүүл мэнд, жендерийн
асуудал хариуцсан мэргэжилтэн



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
“ЖЕНДЭРИЙН ДЭД ЗӨВЛӨЛ”-ИЙН
АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь Эрүүл мэндийн газрын дэргэдэх Жендэрийн дэд зөвлөл /цаашид “дэд зөвлөл” гэх-/ийн зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагаа болон түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Дэд зөвлөл нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Эрүүл мэндийн салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар баримтлах бодлого, Эрүүл мэндийн яамны дэргэдэх Жендэрийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг байгууллага, салбарын хэмжээнд зохион байгуулалтаар ханган ажиллах бүтцийн нэгж юм.

Хоёр. Дэд зөвлөлийн бүтэц, үйл ажиллагааны зохион байгуулалт

- 2.1 Дэд зөвлөлийн бүрэлдэхүүн нь Эрүүл мэндийн газрын хэлтэс, алба болон салбарын байгууллагуудын оролцоог хангасан байх ба эрэгтэй хүйсийн төлөөлөл 20 хувиас багагүй байна.
- 2.2 Эрүүл мэндийн газрын дэргэдэх дэд зөвлөл нь 9-11 хүртэл, сум, өрхийн эрүүл мэндийн төв, харьяа байгууллагын жендэрийн баг нь 3-5 хүний бүрэлдэхүүнтэй байна.
- 2.3 Дэд зөвлөл нь дарга /Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга/, гишүүдээс бүрдэнэ.
- 2.4 Эрүүл мэндийн салбарын харьяа байгууллагуудад жендэрийн баг байгуулан ажиллуулж, энэхүү журмыг мөрдүүлэх ба хэрэгжүүлсэн ажлаа дэд зөвлөлд тайлagnана.
- 2.5 Үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх ба жилд 2-оос доошгүй удаа хуралдах бөгөөд хуралдааныг дэд зөвлөлийн дарга удирдана.
- 2.6 Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг дэд зөвлөлийн даргын санаачилгаар, эсхүл зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар зарлан хуралдуулж болно. Гишүүдийн 50-иас дээш хувь ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно.
- 2.7 Эрүүл мэндийн газрын түвшинд хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэх бол хэлтэс, албаны төлөөллөөс бүрдсэн гишүүд хуралд оролцох ба салбарын хэмжээний асуудлыг бүх гишүүдийн оролцоотойгоор өргөтгөсөн хурал зохион байгуулж, шийдвэрлэх
- 2.8 Хурлын дэгийг энэхүү журамд нийцүүлэн өөрөө тогтооно.
- 2.9 Хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг нийт гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэх ба санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

- 2.10 Хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлаар хурлын тэмдэглэл гарна.
- 2.11 Хуралдааны тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлж, дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
- 2.12 Дэд зөвлөл нь ажлаа Эрүүл мэндийн газрын Удирдлагын багийн өмнө тайлагнана.

Гурав. Дэд зөвлөлийн чиг үүрэг

3.1 Дэд зөвлөлийн дарга дараах эрх, үүргийг эдэлнэ.

- 3.1.1 Дэд зөвлөлийн үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах, зохицуулах
- 3.1.2 Дэд зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг тодорхойлж, хэлэлцүүлэх
- 3.1.3 Дэд зөвлөлийн гишүүдийн хариуцах ажил үүргийг тухайн төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулж, биелэлтийг тооцох
- 3.1.4 Эрүүл мэндийн салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар баримтлах бодлого, Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, Эрүүл мэндийн яамны дэргэдэх Жендэрийн салбар зөвлөл, аймгийн Жендэрийн салбар хорооноос ирүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
- 3.1.5 Дэд зөвлөлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг эрчимжүүлэх үүрэг чиглэлийг гишүүдэд өгөх
- 3.1.6 Дэд зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлаарх холбогдох шийдвэрийн саналыг байгууллагын удирдлагад танилцуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулалтаар ханганд, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах

3.2 Дэд зөвлөлийн нарийн бичиг нь дараах эрх, үүргийг эдэлнэ.

- 3.2.1 Эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л асуудлаар дэд зөвлөлийн даргад тусалж, хамтарч ажиллана.
- 3.2.2 Жендэрийн дэд зөвлөлийн гишүүдийг жендэрийн эрх, тэгш байдлыг хангах чиглэлээрх холбогдох мэдээ, мэдээллээр хангах
- 3.2.3 Хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг боловсруулж, дэд зөвлөлийн даргаар батлуулсан, гишүүдэд урьдчилан танилцуулах
- 3.2.4 Хурлын бэлтгэлийг хангах, хурлын шийдвэр, тэмдэглэлийг хөтөлж, албажуулах, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх
- 3.2.5 Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн тайланг нэгтгэж, дэд зөвлөлд болон Эрүүл мэндийн газрын Удирдлагын багт тайлагнах
- 3.2.6 Хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн тайлан, холбогдох материалыг хавтасжуулж, баримт бүрдүүлэх
- 3.2.7 Хурлын тэмдэглэл, холбогдох тайлан, мэдээллээр архивын нэгж бүрдүүлэн, хуульд заасан хугацаанд байгууллагын архивт хүлээлгэн өгөх
- 3.2.8 Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах чиглэлээр тасралтгүй суралцах, мэргэших, холбогдох эрхзүйн актуудыг тухай бүр уншиж судлан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
- 3.2.9 Эрүүл мэндийн яам болон аймгийн Жендэрийн салбар хорооноос зохион байгуулж буй аливаа үйл ажиллагаанд удирдлага, дэд зөвлөлийг төлөөлөн оролцох

3.3 Дэд зөвлөлийн гишүүд дараах эрх үүрэг хэрэгжүүлнэ.

- 3.3.1 Дэд зөвлөлийн хуралд хүндэтгэн үзэх шалтгаантайгаас гадна бусад тохиолдолд биечлэн оролцох
- 3.3.2 Дэд зөвлөлийн тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан ажлыг чиг үүргийн дагуу хариуцан зохион байгуулж, тайлагнах
- 3.3.3 Дэд зөвлөлийн чиг үүрэгт хамаарах асуудлаар санал гаргах, хуралдаанаар хэлэлцүүлэх
- 3.3.4 Анхан шаты болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын жендэрийн багийг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах
- 3.3.5 Аливаа бодлого төлөвлөлт, төсөвлөлтийг хийхдээ жендэрийн дүн шинжилгээ хийж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэйгээр зохион байгуулж, үзүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх

Дөрөв. Хариуцлага, хяналт

- 1.1 Дэд зөвлөлийн дарга, гишүүд хүлээсэн үүргээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа биелүүлээгүй тохиолдолд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээнэ.
- 1.2 Жендерийн багийн үйл ажиллагаа, Эрүүл мэндийн салбар дах “Жендерийн эрх, тэгш байдлыг хангах талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд дэмжлэгт хяналт, үнэлгээг хийж, хангалтгүй тохиолдолд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага тооцох саналыг байгууллагын удирдлагад хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

Тав. Санхүүжилт

- 5.1 Дэд зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах бичиг хэргийн болон төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг байгууллагын төсвөөс санхүүжүүлнэ.

---Оо---